

Манмин Мэдээ

№ 69 2019 оны 2 сарын 24

“Хоолны дуршилгүй болох хам шинж өвчнөөс эдгэрсэнээс хойш миний шинэ амьдрал эхэлсэн!”



Хоолны дуршилгүй болох хам шинж өвчин нь мэдрэлийн гаралтай хам шинж бөгөөд хоолонд дургүй болох идэх дуршилгүй болох бүр хоолноос айх татгалзах, хүндэрсэн тохиолдолд биед хэрэгтэй шим тэжээлийн дутагдлаас болж амь насаа ч алдаж болох аймшигтай өвчин юм.

Дахин сэдрэх магадлал маш өндөр ба үхэлд хүргэсэн тохиолдол үе үе тохиолддог ч бүхнийг чадагч Бурхандаа найдан түшиглэж, хоолны дуршилгүй болох өвчнөөсөө эдгэрсэн Ким Хе өн эгч дүү (28нас)-гийн гэрчлэлээр дамжуулан амьд орших хайрын Бурхандаа бүх л алдар талархалыг өргөж байна.

Зургийн тайлбар

▼ Бага сургуулийн 5-р ангид байхдаа Ким Хе өн эгч дүү хоолны дуршилгүй болох өвчнөөсөө И Жей руг тэргүүн пасторын залбирал авсаны дараа бүрэн эдгэрсэн нь



Бага сургуулийн 5-р ангид байхдаа, Тэр үед болсон үйл явдал миний амьдралыг шинээр бүрэн өөрчилсөн юм.

Нэгэн өдөр найзуудтай авахуулсан зургаа үзэж байтал, ялимгүй булцгардуу хацартай гэж бодож байсан миний царай дэндүү том харагдаж бусад хүүхдүүдтэй харьцуулан харахад тийм ч аятайхан харагдахгүй байлаа. Би ч тэр даруй турах дэглэм барихаар шийдэж, хоолныхоо хэмжээг багасгахад бага багаар жин хаяж байгаагаа мэдэх сонирхолтой байсан ч нэг л мэдэхэд жингээ хасах тусам илүү хаях гэсэн хүсэлд автаж нэг ёсны донтож байлаа.

Дараа нь хоол идмээргүй санагдаж, хоолны үнэр л авбал цатгалан мэт санагдаж, ээж хоол хийж өгсөн ч хоолоо хувцсандаа нуугаад бүгдийн идцэн гэдэг байлаа. Түүнчлэн хоолны ширээний ард суухаас л бусад үед таргалах вий, жин нэмэх вий гээд өдөржингөө зогсоо байдаг байлаа. Ийм этгээддүү үйлдлийг минь ажигласан ээж маань намайг эмнэлэг рүү дагуулан явсан юм.

“Хоолны дуршилгүй болох хам шинж байна. Мэдрэлийн эмчид үзүүлж эмчилгээ хийлгэх хэрэгтэй болохоор илүү дэлгэрэнгүй шинжилгээг том эмнэлэг рүү явах хэрэгтэй.” гэсэн юм.

Яг 2сарын дотор миний биеийн жин 25кг аар буурч, яс нь хэрдийсэн бүр цогцос шиг нүдэнд хүйтэн харагддаг болсоноо сая л мэдсэн юм. Хөл минь хөхөрч зөвхийж харагдаад, үсний тэжээл дутагдсанаас туг тугаараа унаж, шөнө сайн унтаж чадахгүй гэнэт хашгирч цочиж сэрдэг байлаа.

Эцэст нь би ээжтэйгээ хамт өвчин эдгээх залбирал авахаар И Жей руг

тэргүүн пастор руу очсон юм.

“Хэн таргаллаа гээд ингэж хамаагүй жингээ хасаад байвал яах юм бэ? Тийм хорон бодлоо хаях хэрэгтэй гээд” чин сэтгэлээсээ залбирч өгсөн юм. Түүний дараа үнэхээр гайхамшиг болсон юм. Сайхан унтдаг болж, хоол дуршил сэргэж, ийм тийм янз бүрийн хоол идэж, сайн ч шингэж, удалгүй эв эрүүл болсон юм. Халлелүяа!

Анагаах ухаанаар яах ч аргагүй хоолны дуршилгүй болох хам шинж өвчинг залбирал авч эдгэрсэний дараа би сүнс махан талын хувьд их өөрчлөлт гарсан юм. Бурханы хайр ба ивээл зүрх сэтгэлд гүн суугдаж, авсан ивээлийнхээ ачийг хариулья гэсэн охин больё гэсэн сэтгэл төрж сурагч хүний үүрэг болох хичээлдээ шамдаж эхэллээ. Дунд сургуульдаа бүх сурагчдаас сурлагаараа 3т орж, Ахлах сургуульдаа 1т орж, их сургуульд байхдаа тэнхимдээ хэд хэдэн удаа тэргүүн байр эзэлж байлаа.

Хоолны дуршилгүй болох өвчин эдгэрэх маш хэцүү бөгөөд төгс эмчлэгдэггүй тул загвар өмсөгчид моделиудын дунд амиа алдсан хүмүүс ч байдаг. Тиймээс Бурханы хүч чадал л биш бол ялангуяа би ийм өвчнөөр үхэхээс өөр аргагүй байсан гэдгээ үргэлж марталгүй санаж амьдардаг байв. Оюутан байхдаа ч Бурхандаа алдрыг өргөн агуу ихээр хэрэглэгдэх ажилтан болохын тулд төрөл бүрийн чадварт өөрийгөө бэлдэж уралдаан, шалгуур, үзэсгэлэнд амжилттай оролцож байлаа. Чөлөөт уран бүтээлч, хөтлөгчөөр нэгэн нэвтрүүлэгийн төвийн сонгон шалгаруулалтад тэнцэж моделоор ажиллаж байна.

Миний мөрөөдөл, туйлийн зорилго бол дэлхий даяар 170гаруй оронд амийн сургааль, эрх мэдэлт хүчийг тунхаглаж буй GCN (Жи Си Эн) телевизийн нэвтрүүлэгч хөтлөгч болох явдал юм. Олон хүмүүст бүтээгч Бурхан ба Есүс Христийг дамжуулна гэдэг нь хичнээн агуу бөгөөд ерөөлтэй ажил билээ.

Бид энэ газар дээр амьдарч байгаа учир нь хүний үндсэн үүрэг юу болохыг ухаарч, Бурханыг хүндэтгэн, Түүний тушаалыг сахиснаар, мөнхийн Бурхантай хайрыг өгч авалцах жинхэнэ үр хүүхэд нь болдог.

Энэ мэтчилэн би хэрхэн амьдрах ёстой болохыг өөрийн биеэр үлгэрлэж өгсөн тэргүүн пастортаа талархалыг илэрхийлэн, хараахан дутагдалтай ихтэй ч өдөр бүр Христийн анхилуун үнэрийг тараахын төлөө хичнээн амьдарч байна.

Юуны түрүүнд хоолны дуршилгүй болох өвчнөөс эдгээж өгч, жинхэнэ амьдралын зорилго руу үнэ цэнэтэй амьдралаар удирдаж өгсөн сайн Бурхан Аавдаа бүх талархал алдрыг өргөө.



Ялгаварладаггүй хоёр нүүр гаргадаггүй мэргэн ухаан

“Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж. Үр жимс нь зөв байгчийн үр нь амар тайвныг бүтээгчдээр амар тайванд таригддаг юм” (Иаков 3:17-18).



И Жей руг пастор

- Есүс Христийн нэгдсэн ариун урсгалын ерөнхий удирдагч
- Христийн сайн мэдээ сэргэлтийн холбооны ерөнхийлөгч
- Үндэсний хайрын залбирлын нэгдсэн хорооны хамтын удирдагч
- (GCN) (Жи Си Эн) Глобал Христийн телевизийн ерөнхий захирал
- (WCDN) Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбооны ерөнхий захирал
- (MIS) Манмин олон улсын библийн их сургуулийн захирал
- Нэгдсэн ариун библийн сургуулийн захирал
- Библи судлалын доктор, Теологийн хүндэт доктор
- Христийн телевиз, радиогийн албан ёсны сургаал заагч
- Чусон илбу, Жүнан илбу, Туна илбу, Хангүг илбу, Сөүл сонин Хангёорэ сонин, Кёонхян сонин, Хангүг кёнжэ сонин, Ши са ньюс, Кристиан сонин зэрэг өдөр тутмын сонин, сэтгүүлд итгэлийн амьдралын тухай байнгын нийтлэгч
- АНУ-н Нью-Йорк, Вашингтон, Балтимор, Мерилэнд, Лос-Анжелос, Хавай, Япон, Пакистан, Филиппин, Аргентин, Гондурас, Перу, ОХУ, Герман, Кени, Танзани, Уганда, Конго бүгд найрамдах улс, Израйль Иерусалим, Эстони зэрэг улс орнуудад нэгдсэн их цуглааныг удирдан явуулсан

Нэгэн удаа нэг эмэгтэй ном, бас амттай жигнэмэг худалдан аваад галт тэргэнд суулаа. Түүний суудал нь нэгэн ширүүн бололтой залуугийн дэргэд байлаа. Галт тэрэг ч хөдөлж, бүсгүй номоо уншингаа жигнэмэг идэж байхдаа гэнэт ажиглалат өнөөх залуу өөрийнх амттанаас идэж байгааг анзаарлаа. “Юу вэ? Ямар ч зөвшөөрөлгүй бусдын юмнаас идэж байхнээ, ямар ичдэггүй юм бэ?” гэж бодоод түүн рүү харахад тэр залуу тоох ч үгүй хэв нэг идсээр байлаа. Бүсгүй өөрийн амттан гэсэн үйлдэл үзүүлсэн ч залуу ер тоохгүй байлаа.

Галт тэрэг ч зорьсон газраа бараг хүрэхэд залуу үлдсэн ганц жигнэмэгийг гол “тог” гээд хуваагаад нэг талыг нь бүсгүйд өглөө. Тэгээд “Баярлалаа” ч юмуу “Уучлаарай” ч гэлгүй өөрийнхөө ачааг аваад суудлаасаа бослоо. Бүсгүй мэл гайхсаар үлдэв.

Бүсгүй буухдаа бэлдэж, ачаагаа янзалж байх зуур бүр их гайхширлаа. Өөрийнх нь авсан амтат жигнэмэг цүнхэн дотор тэр чигээрээ байж байлаа. Бусдын юмыг дураараа идэж байсан нь харин өөрөө байснаа ойлгосон юм. Энэ мэт ялгаварлах, өөрийнхөөрөө дүгнэх байдал нь үнэн бус явдалыг үнэн мэт болгох үе байдаг.

Тэр бүсгүй залуугийн гадна байдал төдийлөн аятай бус тул тэрээр бусдын юмыг идэхэд ч сийхгүй гэж шуудхан дүгнэсэн байдаг. Тиймд хүний тухай, тухайн нөхцөл байдлын тухай ялгаварлал байхгүй сэтгэлээр хандаж байж үнэнд илүү ойртох боломжтой юм.

1. Юу ч хийсэн ялгаварлалгүй байхын тулд өршөөнгүй байх хэрэгтэй

“Ялгаварладаггүй” гэдэг нь “Бүх зүйлийг эрх тэгш хандахыг хэлнэ” гэсэн утгатай. Цаг үргэлж ганхалгүй хэнтэй ч харьцсан нэг хэвээр байдаг. Гадна төрх, эдийн засгийн байдал, үзэл бодол, боловсрол зэргээс хамаарч харьцах байдал өөрчлөгдөггүй байхыг хэлдэг. Юу ч хийсэн ийм байхын тулд энэрэнгүй өршөөнгүй байх хэрэгтэй юм.

Бидний сэтгэлд хайр ба өршөөл энэрэл байхгүй бол Бурханы сургаалийг их суралцлаа гээд түүнийгээ зөв ашиглаж чаддаггүй. Жишээ нь Бурханы үгэнд “Дайснаа хайрла” гэдэг ч яг өөрт нь тулаад хохирол үзүүлэх юм уу ойлгомжгүй хүнтэй тулвал тэр хүнийг хайрлана гэдэг нь амаргүй байдаг. Өөрийн үзэл, зан авир, өөрийн зөв гэсэн байдалд нийцүүлэх гэдэг учраас юм.

Адилхан хүнийг томруулдаг шилээр харвал томорч харагддаг, харин нөгөө талаар нь харвал цонхигор нарийн харагдуулдаг. Хэрэв энэ шилээр харсаны дагуу “бүдүүн байна. Чөргөр байна” гэвэл юу болох вэ? Хүний үүднээс “Намайг харахад туранхай байсан” гэдэг ч үнэхээр ч бодит байдлаас өөр тул худал үг болдог. Ийм учраас бусдыг шархалуулж ч болзошгүй юм.

Хайр ба өршөөл сэтгэлд байхгүй байх тусам амархан ганхах, бусдын байдал өөрийн бодолд нийцэхгүй бол бусдыг амархан дүгнэж шүүдэг. Энэ мэт өрөөсгөл явцуу байдлаар бусадтай хандвал түүнд зайлшгүй худал хуурмаг холилдохоос аргагүй юм.

Шударга бөгөөд хайр, өршөөлөөр дүүрэн хүн

бол бусдын ямар ч байдлыг харсан шүүмжилж буруутгадаггүй юм. Өршөөнгүй сэтгэлээр хучиж далдлах гэдэг. Өршөөнгүй сэтгэл нь амь амьдралийг тэтгэх сайны үр жимс бий болгодог бол ялгаварлах сэтгэл нь дүгнэх шүүх, үнэнийг гажуудуулах амьдралыг хорлон сүйтгэх, хорон муу үр дагавартай юм.

Есүсийн үйлчлэлийн үед фарисайчууд хуулийн багш нар Бурханы үгийг заах байр суурьтай байсан юм. Тийм ч учраас өөрсдөө хуульд нэвтэрсэн гэж бүрэн итгэлтэй байдаг. Тиймээс өөрийн зөв гэж өөрийн үүднээс ялгавартай хандсанаараа хуулийг өөрсдийнхөөр тайлбарлаж, үүнд нийцэхгүй хүмүүсийг гэмтэн нүгэлтэн гэж үздэг байлаа.

Тэд Есүсийг амралтын өдөр өвчтэй хүнийг эдгээсэн явдлыг ‘Амралтыг өдрийг зөрчсөн хорон муу үйлс’ гэж бодож байлаа. Уг нь Бурхан амралтын өдрийг сахих нь шууд л ажил бүү хий гэх бус ‘Сүнс талаар амралтыг эдлээрэй’ гэсэн утгатай.

Өвчтэй хүнийг эдгээх юм уу, сайн мэдээ тарааж хүмүүсийг аврах ажил нь өөрийн эрх ашгийн дагуу хийдэг хар ажил биш амралтын өдөр мэдээжийн хийх ёстой сайн үйлс юм. Тийм учраас тэд өөрсдийн үүднээс ‘Амралтын өдрийг зөрчлөө’ гэж дүгнэн, ‘Бурханыг эсэргүүцдэг хүн’ гэсэн шийдвэрийг гаргасан байдаг.

2. Бүх зүйлд нийтийн эрх тэгш байдлаар хандах

Олон хүмүүс өөрсдийн туйлшрамтгай байдлын улмаас өдөр тутмын амьдрал дунд худал хуурмагын үрийг хэр зэрэг тарьж байгаагаа ухаардаггүй. Эцэг эхчүүд хүүхдээ зэмлэхдээ ч мөн адил юм. Ах дүү 2муудалцах үед эцэг эх нь ахаас нь муудалцах шалтгааныг нь асуувал “Дүү л түрүүлээд цохьсон” гэх. Зөвхөн энэ үгийн дагуу бол дүү нь илүү буруутай мэт болох бол, дүүгээс нь учрыг асуувал “Ах өөрөө миний тоглоомыг булаах гэсэн тэгээд би цохьсон” гэж хэлсэн байдаг.

Хэрвээ эцэг эх ахын үгийг сонсоод уурлавал дүүд хичнээн эвгүй бөгөөд хэцүү байх бол? Ердийн үед ихэнхдээ ахынх нь талд ордог, дүү нь маш дүрсгүй байдаг болохоор ахын үгийг сонсдог эцэг эх ч байдаг. Гэтэл ухаалаг эцэг эх бол бүх зүйлд эрх тэгш тэнцвэртэй ул суурьтай ханддаг болохыг харж болно.

Үүнээс гадна өөрийн эрх ашиг бодолд нийцүүлэн үнэнийг гажуудуулах тохиолдол их байдаг. Ялгаварлах туйлшрах хандлага байвал өөрөө ч мэдэлгүй үг үйлдэл нь хуурмаг байдаг. Гэтэл хайртай дотны хүн нь буруу юм хийсэн тухай сонсогдвол “тийм байж таарахгүй” гэж бодон түүнд нь итгэхгүй “тэгэх шалтгаан байсан байлгүй” гэмэгцээ яадаг ч байсан түүнийхээ алдаа дутагдлыг нуун далдлах гэдэг. Эсрэгээр нь дургүй хүн юм уу муу зуршилтай хүний тухай муу сураг чимээ дуулдвал шууд л итгэж орхидог.

“Өмнө нь ч тэгж байсан, бас тэгж дээ тэгнээ тэр”, “яагаад ч юм санаанд нийцдэггүй юм” гэж улам туйлширч эхэлдэг. Ийм шинж чанар байгаа тул үнэнийг мэдье гэхээс илүү тухайн сураг чимээг шууд хүлээн авч бусдыг дүгнэдэг.

Бас нэгэн жишээ дурьдвал өөдөөс ирж яваа хүн


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг

Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

тань та бүхний харцнаас зайлсхийн хурдхан зөрөөд өнгөрлөө гэж бодъё. Завгүй явж байсан болохоор эсвэл өөр юм бодож явахдаа эргэн тойрноо анзаараагүй байж ч болох, эсвэл хараа муутай учраас орчноо муу хардаг ч юм уу өөрийнхөө төрхнөөсөө ичээд дөлсхийгээд явж өнгөрч болох юм. Тийм ч учраас бусдын талаарх хайр ба өршөөнгүй сэтгэл байхгүй бол, ийм дүр төрхийг хараад муу талаар дүгнэхдээ маш амархан байдаг.

‘Бүдүүлэг юм’ гэх юм уу ‘надад дургүй юм болов уу’ гээд өөрийн мэдрэмж, сэтгэл хөдлөл дотроос тайлбарлах гэдэг. Энэ мэт өршөөл ба хайр байхгүй байх тусам туйлшрах хандлагаар ийм тийм бодолд автахад хялбар байдаг. Тийм учраас Ариун Сүнсний дуу хоолойг сонсох боломжгүй ба үнэнийг мэдрэх боломжгүй юм.

Аль нэг талыг сонгох ёстой нөхцөлд, мөн зөвлөмж авах үедээ ч хэдийн өөрийн хүссэн өөрт таатай тал руу хэлбийх нь элбэг байдаг. ‘Аль нь Бурханы өмнө зохистой’ болохыг хайхаас илүү ‘Өөрийн хүсэж буй зүйлээ хийж болох’ эсэхийг юуны түрүүнд лавлах тохиолдол юм. Ийм тохиолдолд зөвлөгөө авахдаа ямар ч хариулт авсан өөрт таатай байдлаар тайлбарладаг. Зарим тохиолдолд зөвлөгөө авахдаа өмнөх нөхцөл байдлаа тодорхой хэлэлгүй, өөрт ашигтай байдлаар ярьдаг байдаг бөгөөд үүнийг сайн ялгаж тухайн шалтгааныг сайн таниж байж зөвлөгөө өгөх хэрэгтэй.

3. Бүх зүйлд ялгаварлалгүй, хоёр нүүргүй үнэнч байхын тулд

Ихэнх тохиолдолд хүмүүс хоорондын харилцаан дахь зөрчилдөөнд зовиурлаж буй хүн нь бусдад л асуудал байгаа мэтээр ярьдаг. Гэвч нөгөө талаас нь шууд лавлахад байдал өөр болохыг мэдэх болдог. Тиймээс нэг талын яриаг сонсоод эрх тэгш, тэнцвэртэй шийдвэр гардаггүй Тэгвэл бүх тал дээр ялгаварлал ба хоёр нүүргүй байхын тулд яах ёстой?

1) Сул дорой нэгэнд туйлширч хандана гэдэг үнэний дотор ялгаварлаж байгаа хэрэг.

Египетээс гарсан нь номын 23:3д “Шүүх дээр ядуу хүнийг бүү ялгаварла” гэсэн байдаг Энд хэлж буй “Ядуу хүн” нь эд хөрөнгийн хувьд хүнд хэцүү төдийгүй, хүч сул дорой хүнийг ч мөн нийтэд нь илэрхийлсэн үг юм. Ашиг сонирхолын үүднээс баян чинээлээг, эсвэл эрх мэдэлтэй хүний талд орж, ядуу дорой гэсэн шалтгаанаар шууд ялгаатай хандах, эсвэл дотно таньдаг мэддэг гээд нэг тал руу хэлбийвэл зөв шүүлт болохгүй гэсэн үг юм.

Хүчтэй хүчгүй хоёр маргалдах үед хүмүүс

хүчгүйх нь тал орвол зөвт үйлс гэж боддог. Харин хүчтэйгийнх нь талд орвол олиггүй, арчаагүй үйлдэл мэтээр ойлгодог. Энэ ч бас зөв биш юм. Зөвхөн Бурханы үгээр л ялгаж салгаж дүгнэх хэрэгтэй. Бурхан баруун зүүн гэж хэлбийлгүй маш тодорхой зөв бурууг ялгахдаа хайр болон өршөөлийн нүдээр ялгахыг хүсдэг.

2) Шууд харж, сонсоогүй л бол бусдыг үгийг сонсоод яаран дүгнэж болохгүй.

Бид урьдчилан таамаглах, туйлширсан бодолтой бол өөрөө шууд үзэж харж, сонслоо ч үнэнээр ялгахад бэрхшээлтэй байдаг Бүр бусдын үгийг сонсоод яаран дүгнэлт хийх таамаглал төдийгөөр шийдвэр гаргавал илүү том алдаа гаргаж ч болзошгүй юм. Бүх зүйлийг эрх тэгш, тэнцвэртэй нарийн судлалгүй бусдын үгэнд л итгэвэл буруу үр дагавар гарах нь зайлшгүй.

Бодит амьдрал дээр адил юм. Ялангуяа том ашиг сонирхол нүдний өмнө байвал илүү амархан бусдыг үгээр болдог. Жишээ нь ямар нэг бизнес өндөр ашигтай байна гэсэн үгийг сонсоод их хэмжээний мөнгөөр хөрөнгө оруултал луйвардуулах юм уу, их хэмжээний хохирол амсвал хэнд гомдох вэ? Тухайн бизнесийнхээ тухай сайтар судалж, тухайн хүнээ олон талаас нарийн шинжилж үзэх хэрэгтэй юм. Үнэхээр итгэл хүлээх харилцагч нартай юу үгүй юу, ашгийн орлогийн тооцоо болон хугацааг маш нарийн нэг нэгдгүй тооцож үзэх хэрэгтэй юм. Мөн ийм аж ахуй бизнесийн үйл явдал бус бусад тал дээр ч ийм тооцоолол хэрэгтэй юм.

Харж, сонсоод дүгнэх бүх зүйлд нухацтай хандаж байж зүрх сэтгэлээ илүү бат бөх тэнцвэртэйгээр аливаад хандах болдог.

3) Ямар нэг үг хэлэх эсвэл бодохдоо тавгүйрхэх болон өөрийн далд санаагаа хаях хэрэгтэй.

Хүмүүсийн ихэнх нь өөртэй нь дотно байдаг юм уу өөрт нь сайн ханддаг хүнд илүү нээлттэй байдаг. Тэгтэл дотно бус хүн нь ямар нэг дүрэм журмыг зөрчвөл “Бардам учраас дэг журам эвдэж байна. Бүдүүлэг авирлаж байна” гэдэг. Гэтэл өөрийн гэр бүлийн хүн, эсвэл дотны хүн нь тэр дүрэм журмыг зөрчих “Тэгэх шалтгаан байсан байх” гэж зөөлрүүлж боддог.

“Хүүхдүүдийн зодоон томчуудын зодоон болдог” гэсэн үг байдаг. Хүүхэд хөрш айлынхаа хүүхдэд зодуулаад ороод ирэхэд буруу зөвийг нь ялгахын оронд сэтгэл хөдлөлөө түрүүнд тавьдаг эцэг эхчүүдийг дээрх үг хэлсэн байх. Өөрийнхөө хүүхдийн бусдыг цохиж зодсоныг бус зодуулсан шархыг хараад уурлаж бухимддаг тул тийм байдал хүргэдэг юм.

Мөн хурал дээр ердийн үед өөрийн таагүй

хүн санал дэвшүүлэхэд тэр үзэл бодлыг нь ганцаараа ч хамаагүй дэмжихгүй буруутгах хандлагатай байдаг бол эсрэгээрээ дотныхоо хүний саналыг илүү идэвхтэй дэмжих тал руу зүтгэдэг. Энэ мэтчилэн ялгаварлах сэтгэл байгаа бол нүд амархан халхлагддаг. Түүнчлэн юу ярих, ямар нэгэн зүйл бодож байхдаа тавгүйрхэх, өөрийнхнийг эрэх далд санаа байна уу гэдгээ анзаарах хэрэгтэй юм.

Өөрийн хайрладаг хүн, ойр дотны хүнтэй холбоотой ажил бол тэр тусмаа эрх тэгш тэнцвэртэй хандах хэрэгтэй юм. Ялангуяа өөрийн байр суурь өндөр түвшиний эрх мэдэлтэй бүр анхаарах шаардлагатай. Өөрийгөө харахад нэг тийш хэлбийгээгүй гээд ‘Энэ зэргийн зүйлд гайгүй биз’ гэж бодсон зүйл нь бусдыг харахад бас л өөрийнхний талд орлоо гэж бодож болох юм.

4. Бүх зүйлийг сайнаар бодож, үнэнээр тунгааж ялгах мэргэн ухаан

Эбид гэм нүглийг хаян, ариусах тусам хүний сэтгэл болон үйлдлийг тодорхой ялгах чадвартай болдог. Үнэний үгээр бусдын сэтгэлийг тунгаан, ямар ч үед хорон муугаар дүгнэдэггүй учраас үнэн зөвийг олох боломжтой юм.

Түүнчлэн ялгаварлах явдалгүй Бурханы хүслийг мэдүүлэхийн тулд зүрх сэтгэлийн ариун байдал маг чухал юм. Үзэн ядалт, уур уцаар, атаархал, шунал, дүгнэн шүүх, бардамнах зэрэг сэтгэл дэх атгаг байдлыг бүгдийг нь хаях хэрэгтэй юм.

Ингэж ариун байдлыг олсоноор юуг ч сайнаар харж, мэдэрч, сайнаар бодож тунгаан зөв дүгнэлт гаргах боломжтой. Бүх зүйлийг сайнаар бодож, үнэний үгээр ялгаж тунгаавал мэдээжийн хорон муугаар шүүж дүгнэх байдал гарахгүй юм. Тэгээгүйгээс болж өөрийн хүсэлд нийцүүлж шүүж, буруу ойлгогдох юм уу шархалуулдаг.

Есүс “Хоёр нүүрт хүн чи, эхлээд нүднээсээ дүнзээ авч хая, тэгвэл чи ах дүүгийнхээ нүднээс үртсийг авч хаяхдаа сайн харах болно” (Матай 7:5) гэсэн байдаг. Сэтгэлд нь хайр байхгүй тул өөрт нь дүнз мэт том гэм нүгэл байгаагаа мэдэлгүй ялгаварлал болон хоёр нүүрт сэтгэлээр бусдаас өө хайж, явдаг. Тиймд хайр ба өршөөлийг сэтгэлдээ хурдан бий болгож, нэг тал хэлбийж ялгаварлах явдал байхгүй байхыг хүсье

Хайрт итгэгч та бүхэн,


Сэтгэлийн гүн дэх гэмийн шинж чанарыг ч хаясанаар болор мэт тунгалаг, эрдэнэс мэт үзэсгэлэнтэй сэтгэлийн нүдээр бүх зүйлийг эрх тэгш байдлаар ялгаж, тунгаасан ухаалаг итгэгч болохыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

“Чих орсон зөгий, залбирал авсаны дараа гаргаж авлаа!”

Батма Приа итгэгч (36нас, эм, Энэтхэг, Ченнай Манмин чуулган)

Энэ оны 1-р сарын 19-ны өдөр шөнийн 11 цагийн үед юм. Би гэртээ унтаж байтал гэнэт зүүн талын чих рүү ямар нэгэн юм ороод гэнэт цочин сэрлээ. Гэрийн маань ойролцоо хар зөгийнүүд их байдаг ба тийм хар зөгийн чихэнд минь орсон байлаа.

Зөгий шөнөжингөө чихэн дотор сэрчигнэн дуугарч нааш цааш хөдлөөд зүүн чих толгой минь маш их өвдсөн юм. Миний энэ зовиуртай байдлыг харсан нөхөр маань чих коконатийн тос дусааж тэр зөгийг авах гэсэн боловч улам цаашилсан байдалтай болов.



Арван дөрвөн настайдаа буюу бага залуу байхдаа гэрлэж төрүүлсэн том охинтойгоо би өглөө нь эмнэлэг рүү явлаа. Эмч энд зөгийг авах

боломжгүй тул илүү том эмнэлэг рүү явахыг зөвлөсөн юм. Тэгээд манай том охин Хан Жон хи пасторт миний байдлыг хэлж И Жей руг тэргүүн пасторын өвчин эдгээх залбирал аваарай гэсэн юм

Би энэ хугацаанд ажил хийж байгаа завгүй гэсэн шалтгаанаар Эзэний өдрийг бүрэн сахидаггүй байсандаа гэмшиж, тэргүүн пасторын өвчин эдгээх



Батма Приа итгэгч (зүүн талаас гуравдах) мөн үр хүүхдийн хамт Бурханы хүчийг мэдрэн гэр бүлээр аз жаргалтай итгэлийн амьдралаар амьдарч байгаа нь Хамгийн зүүн талаас том охин Нивета нь арьсны тууралт өвчнөөс, хүү Дэбираж нь зүрхний өвчнөөс, бага охин Лабита нь бамбай булчирхайн томролт, гар хөл салгалах өвчнөөс бүрэн эдгэрч Бурхандаа алдрыг өргөсөн юм.

залбирлыг авсан юм. Ажилдаа хоцорч очсон ч ажил дээр дахин залбирал аваад, хамт ажилладаг хүмүүстээ “Өнөөдөр ажил тарахын өмнө чихэнд орсон зөгий заавал гарна” гэж итгэлээрээ хэлсэн. Тэгээд үдээс хойш 4:30н үед хамт ажилладаг хүмүүсийн хамт үхсэн байсан зөгийг хавчаараар гаргаж авч чадсан юм. Халлелүяа!

Энэ удаагийн үйл явдлаар амралтын өдрийг төгс сахиын чухалыг ухаарч Эзэний илүү хайрлах боломжоор ерөөж өгсөн Бурхан Аавдаа, бүх талархал алдрыг өргөө. Эрхэм амийн сургиалиар тэжээн тэтгэдэг тэргүүн пасторгаа гүн талархал илэрхийлье.

Амийн сургаалиар дахин төрж, авралын бат итгэлээр сайн мэдээг тараан, салбар танхим байгуулах ерөөл авлаа!



Ектор Антонио Аяалла итгэгч (51нас, Гондурас, Сан Педро сул)

2007оны эхээр нэгэн өдөр Гондурас JBN TV-р 'Итгэлийн хэмжээ' гэсэн сэдэвтэй нэгэн семинарийг үзэж байлаа. Би маш гүнзгий утга бүхий тэр сургаалиас маш их ивээл авсан юм. Гондурас төдийгүй Америк тивийн бүх газраас ямар номлогч нараас сонсож үзээгүй сургааль байлаа.

Зөгийн бал мэт амтат амийн сургаалийг хайн Манминий итгэгч болсон нь

Энэ сургаалийн эх үүсвэр болох Солонгос дахь Манмин төв цуглааны тэргүүн пастор И Жей руг пасторын сургаалийг интернэтээр хайж сонсч эхэлсэн юм. Би 'Загалмайн үг', 'Тэнгэрийн орон', 'Там', 'Итгэлийн хэмжээ' гэх мэт эрдэнэс мэт үг сургаалийг сонсож, авралын бат итгэл болон тэнгэрийн орны хүсэл тэмүүлэлээр дүүрсэн юм.

Эцэст нь 2011онд интернэтээр бүртгүүлсэн ч цагийн зөрүүнээс болж мөргөлийн шууд нэвтрүүлгэд оролцоход амар биш байв. Тэгээд манминтай адил итгэлийн амьдралтай сүмийг хайж эхлэсэн юм. Эзэний өдрийн их мөргөлийг өргөхийн тулд хэд хэдэн сүмд очиж үзсэн ч сэтгэлд хүрэх хэмжээний цуглаан олж чадаагүй тул Манмин сүмийг санагалзах улам их болсон юм.

2015оны 11-р сард баяртай мэдээ сонссон юм. Манмин төв сүмийн пасторуудын ерөнхий удирдагч И Сү жин пастор Гондураст айлчилж, сэргэлтийн цуглаан удирдах тухай юм. Би гурван удаа уг цуглаанд оролцож, библи дээрх сургаалийг маш тодорхой дамжуулж буй ариун сайн мэдээнд талархаж, энэ мэт Бурханы хүслийг зөв ойлгож, итгэлээр амьдарна гэдэг нь үнэхээр сэтгэл хөдлөм байлаа.

Хүсэн тэмүүлж буй хүмүүс цуглан салбар танхим байгуулан

Тэгж байгаа нэгэн өдөр цахимаар тэргүүн пасторын сургаалийг тарааж таниулдаг Карлос Леон ахан дүүтэй танилцсан юм. Түүний танилцуулсан сүмийн цуглаанд оролцож үзсэн сэтгэл хангалуун байж чадахгүй л байлаа. Яагаад гэвэл Манмин төв сүмтэй ижилхэн итгэлийн амьдралаар заадаг сүмийг л хайж байсан болохоор юм.

2017оны 9-р сараас тэргүүн пасторын амийн сургаалийг хүсэн тэмүүлж буй хэдэн итгэгч хүмүүстэй Эзэний өдөр болгон бие биенийхээ гэрт тойрон хамтдаа мөргөл хийж эхэлсэн юм. Тэгж байгаад талархалтай нь Колумби Манмин цуглааны Жан Жон ёон пастортой холбогдож, Юутүбээр Колумби Манмин цуглааны бүх мөргөл болон үйл ажиллагаатай хамт байж эхэлсэн юм. Өдөр бүр Даниел залбирлын цаг, төрөл бүрийн мөргөлтэй хамт байж, биднээс гадна Бразил, АНУ, Аргентин, Венесуель, Эквадор, Чили зэрэг 30-40 газраас холбогдож байгаа юм.

2018оны 3-р сард тусдаа өөр газар олж, салбар танхим байгуулж, одоо 18итгэгч Ариун Сүнсээр нэгдэж, итгэлийн амьдралаар амьдарч байна. Бид нар Бурхан Аавын болон Эзэний хайрыг мэдэрч, эдгэрэл хариулт төдийгүй эд хөрөнгийн ерөөл ч авсаар байна.

Эдгэрэл, хариулт, ерөөл дунд амьд орших Бурхантай уулзан

Бланка Кларос (эм/45нас) гэнэт нуруугаар хүчтэй өвдөн нойрноос сэрсэн бөгөөд биеэ хөдөлгөж ч чадахгүй хөшингө үхмэл мэт болсон айдас нөмөр авсан юм. Гэтэл охиныхоо тусламжтайгаар И Жей руг тэргүүн пасторын залбирч өгсөн гар алчуураар (Үйлс 19:11-12) биед хүргэж өвчний төлөө залбирч өгөхөд түүний дараа өвчин хөндүүр арилж, хэвийн болсон юм.

Исис Жоссели Паз (эм/24нас) арьсны өвчнөөсөө эдгэрэх гэж тэргүүн пасторын залбирал авахыг хүссэн утга бүхий мейлийг Солонгос МанМин төв сүм рүү явуулсан байдаг. Мөн өөрийгөө эргэн харж, залбирал хийж өөрчлөгдөх гэж хичээн зүтгэсэн юм. Түүний үр дүнд цаг орон зай хамаарах тэргүүн пасторын өвчин эдгээх залбирлаар төгс эдгэрч, Тэнгэрийн орны тэмүүлэлээр илүү ихээр бялхаж байна.

Пернандо Мартинез (эр/37нас) '2002оны И Жей руг пасторыг урьж оролцсон Гондурасын нэгдсэн их цуглаан'-д оролцож амийн үг сургаал эрх мэдэлт хүчийг өөрийн биеэр харж, маш их сэтгэл хөдлөн догдолж, тэр үеийн халуун урьдийн хэвээр байгаа гэсэн юм. Сүүлийн үед тэргүүн пасторын сургаалиар дамжуулан Бурханы айлдсан Аравны нэг өргөлийг хэрхэн өргөх тухай аргыг сурч хэрэгжүүлсэнээр эд хөрөнгийн ерөөл хүртэл авсаар байгаа гэсэн юм.

Мөн хүчтэй өвддөг байсан толгойн өвчнөөсөө эдгэрч, түүний эхнэр дэлгэцээр дамжуулан тэргүүн пасторын царайг харах тэр агшинд өвчин зовиур арилсан гайхамшгийг авсан юм.

Гэр бүлд жинхэнэ итгэлийг бий болгож буй аз жаргал бялхаж

Энэ мэт Гондурас дахь салбар танхим байгуулагдсанаас хойш амийн сургаалиар дамжуулан жинхэнэ итгэлийн амьдралын тухай олон зүйлийг сурч байгаа тул маш аз жаргалтай байна. Манминий үг сургааль бидний сэтгэл дэх хорон мууг илрүүлж өгч, түүнийг хэрхэн хаях аргыг хүртэл зааж өгдөг. Бид яаж залбирах ёстой болохыг Аравны нэгийн өргөл хэрхэн өргөдөг болохыг сурч, үйлдэх тусам итгэлээр өсч, өөрөөрөө үлгэрлэж буй И Жей руг тэргүүн пасторыг дагаад зүрх сэтгэлийн хөвч хөндөлтийг төгс хийхээр зүтгэж байна.

Манай гэр бүл төдийгүй Манмины итгэгч болсоноос хойш хүүхдүүд маань өөрчлөгдөж, өглөө оройгүй залбирч, хамгийн үзэсгэлэнтэй Шинэ Иерусалим руу орохын тулд тасралтгүй хичээсээр байна. Би ч эхнэртэйгээ цуг хичээнгүйлэн өөрчлөгдөхийг хүсэн тэмүүлж зүтгэхэд эрүүл мэндийн болон эд хөрөнгийн ерөөл зэрэг сүнс махан талаар ерөөгдсөөр байна.

Хайрын Бурхан бидний Манминий итгэгчээр дуудаж өгч, авралын бат итгэл дотор итгэлийн амьдралаар амьдаруулж ерөөж өгсөн юм. Юуны түрүүнд жинхэнэ Бурханы хүнтэй уулзуулж амийн сургааль ба эрх мэдэлт хүчний үйлээр дамжуулан хамгийн агуу зүйлийг авсан юм. Тэр агуу хайранд талархаж, ариун байдлын замаар удирдах ерөөлт сайн мэдээг илүү олон хүмүүст дамжуулмаар байна.

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manmininen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин